



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Айраг сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/7/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.GOV.MN

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор: У.Оюунтүлхүүр

Утас: Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	6
2.1.	Оршил.....	6
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	8
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	9
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	9
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	10
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	10
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	11
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
2.11.	Шилэн дансны мэдээлэл	13
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	13
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
3	Менежментийн захидал	15
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15

1 Аудитын гэрчилгээ

Д. ХИРСЭН



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

№ _____
танай _____ -ны № _____ -г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Айраг сумын төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Айраг сумын төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Айраг сумын төсвийн Төвлөрүүлэн захирагч нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Айраг сумын төсвийн Төвлөрүүлэн захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Айраг сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Л.Мөнхжаргал-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Айраг сумын Засаг дарга 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Айраг сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.11-наас 2019.03.13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Айраг сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.03.04-ны өдрийн 5/119 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Айраг сумын Засаг дарга талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Айраг сумын Засаг дарга нь Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод шуурхай хүргэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Айраг сумын Засаг дарга үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн байгууллагын үйл ажиллагаа

Айраг сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний (6) байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас (6) байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Айраг сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	4	4		2	
2	ТБОӨААН					
	Дүн	4	4		2	

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Айраг сумын Засаг дарга мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Айраг сумын Засаг дарга санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Айраг сумын Засаг дарга нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашигладаггүй байна.

Айраг сумын Засаг дарга дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй гэж үзлээ.

Айраг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын алба хяналт шалгалт хийгээгүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд төрийн аудитын байгууллага хяналт шалгалт хийжээ. Аудитаар илэрсэн алдаа зөрчил байхгүй байна

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Айраг сумын Засаг дарга бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийн 1 хувиар сонгов.

Цэвэр хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн суурийг хэвээр авсантай холбоотой юм.

Айраг сумын Засаг дарга 2018 оны цэвэр хөрөнгө 7,605,638.5 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 76056.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн шатанд дундаж хувиар сонгосонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Айраг сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 25.9 сая, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 1.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 4.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Үүнээс: Залруулгын ангилал

№	Залруулгын товч утга	Мөнгөн дүн (мянган төгрөгөөр)	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой	Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой
1.	Сум хөгжүүлэх сангийн зээлийн алдангийн орлогыг дутуу илэрхийлсэн			1532.2		
	Дүн			1532,2		

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	6	7686.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	188.6	
3	Албан шаардлага өгсөн	1	21534.9	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	8	29410.4	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Илрүүлэлт: Айраг сумын СХСангийн зээлийн алдангийн орлогыг үр дүнгийн тайланд дутуу тусгасан

Шийдвэрлэсэн: СХСангийн зээлийн хүүгийн алдангийн 1532.2 мянган төгрөгийн орлогыг үр дүнгийн тайланд залруулан орлогоор бүртгэх

Илрүүлэлт: Айраг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2018 онд үдийн цай хөтөлбөрийн хүрээнд хоол хүнс 21,534.9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил үйлчилгээнд сургуулийн захирлын 2018/08/29-ны өдрийн А/30 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулагдаж 2018/08/30-нд сонгон шалгаруулалт хийх тов гарсан байна. ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөн ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөн ажиллах тухай албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Айраг сумын Засаг дарга чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 9 хөтөлбөр, 212 арга хэмжээнд зориулан 2,061,616.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Айраг сумын засаг даргын 2018 оны төсвийг 2017 оны 12 сарын 05 ны өдрийн Сумын ИТХ-ын 05/22 тогтоолоор баталсан бөгөөд 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 03/02 тогтоолоор тодотгол хийсэн байна.

Сумын татварын болон татварын орлогыг 54,220.0 мянган төгрөгөөр татварын бус орлогыг 6500.0 мянган төгрөгөөр нийт орлогыг 60,720.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тусгай шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 1,637,789.6 мянган төгрөг, ОНХсангийн санхүүжилт 95,030.8 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс санхүүжих 268,076.5 мянган төгрөгөөр нийт төсвийн орлогыг 2,061,616.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын санхүүжилт 41335.0 мянган төгрөгөөр, СЗДТГазар 287,461.5 төгрөг ОНХСан 95030.8 мянган төгрөгөөр, тусгай шилжүүлгийн байгууллагын шилжүүлэг 1,637,789.6 мянган төгрөгөөр нийт төсвийн зарлагыг 2061616.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Нөхөн сэргээлтийн сангийн орлого зарлагыг 56000.0 мянган төгрөгөөр, Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагыг 155000.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл:

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Үйл ажиллагааны орлого	4600.0	4683.7	83.7	101.8
2	Хадгаламжийн хүүгийн орлого	14100.0	14764.7	664.7	104.7
3	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	12600.0	13297.2	697.2	105.5
4	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	4433.0	4593.7	160.7	103.6
5	Бууны татвар	1936.0	2057.0	121.0	106.2
6	УТХ	1650.0	1650.2	0.2	100.0
7	Хог хаягдлын хураамж	16198.0	17559.0	1361.0	108.4
8	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1050.0	1050.0	0	100
9	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4153.0	4153.6	0.6	100
10	Татварын болон татварын бус орлогын дүн	60720.0	63809.1	3089.1	105.1

Сумын ИТХ болон ЗДТГ-ын төсвийн гүйцэтгэл 321140.4 мянган төгрөг буюу 97.7 хувьтай, тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 1637802.4 мянган төгрөг буюу 100.0 хувь байна.

Батлагдсан төсвийн давсан орлого 3089.1 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Айраг сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Айраг сумын засаг даргын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Айраг сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 12.2 хувь буюу 4085.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ			1	1532.2	1	1532.2	1	1532.2
2	ТШЗ	8	29410.4	1	2553.0	9	31963.4	1	2553.0
3	ТБӨӨААН	8	29410.4	2	4085.2	10	33495.6	2	4085.2
Дүн									

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил	Хариуцлага тооцуулах санал				Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
			Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах санал	

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ											
2	ТШЗ	8	29410.4	1	188.6	1	21534.9	6	7686.9	-	-	-
	Дүн	8	29410.4	1	188.6	1	21534.9	6	7686.9			

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Айраг сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Айраг сумын Засаг дарга 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан			Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	
1	ТШЗ	3	1		4
2	ТБОӨААН				
	Дүн	3	1		4

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	763,050,493.93	754,018,309.95
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	256,545,324.50	300,846,862.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	256,545,324.50	300,846,862.00
31210	Төгрөг	256,545,324.50	300,846,862.00
31211	Төрийн сангийн харилцах	256,545,324.50	300,846,862.00
33	АВЛАГА	139,436,512.50	76,923,186.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,442,980.00	0.00
33500	Бусад авлага	34,833,172.00	20,130,263.00
33510	Байгууллагаас авах авлага	34,833,172.00	20,130,263.00
33600	Зээлийн авлага	101,160,360.50	56,792,923.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	101,160,360.50	56,792,923.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	101,160,360.50	56,792,923.00
35	БАРАА МАТЕРИАЛ	367,068,656.93	376,248,261.95
35100	Түүхий эд материал	36,849,685.77	40,607,372.89
35110	Тусгай зориулалттай материал	34,950,192.54	37,478,963.19
35130	Эм боох материал	1,899,493.23	3,128,409.70
35400	Хангамжийн материал	323,477,671.16	328,768,089.06
35410	Бичиг хэргийн материал	3,962,150.00	4,329,258.00
35420	Аж ахуйн материал	9,356,743.00	10,923,019.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,643,185.00	2,783,805.00
35440	Түлш, шатах тослох материал	221,510.00	2,816,380.00
35450	Барилгын засварын материал	1,099,945.00	1,792,925.00
35460	Хүнсний материал	13,822,062.70	15,916,277.50
35470	Бусад хангамжийн материал	291,372,075.46	290,206,424.56
35600	Мал амьтад	6,741,300.00	6,872,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,407,779,671.23	6,872,598,549.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,407,779,671.23	6,872,598,549.07
39200	Биет хөрөнгө	5,407,270,088.25	6,700,567,382.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,488,239,464.60	5,667,004,117.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,181,600,470.60	-11,846,548.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	162,254,300.00	185,451,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-130,703,664.12	-117,896,064.21
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	590,617,874.21	624,297,591.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-342,633,689.04	-426,282,882.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	280,041,236.95	254,340,823.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-129,360,386.79	-119,256,051.20

Айраг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39214	Бусад үндсэн хөрөнгө	1,132,154,283.04	891,681,563.65
39215	Хуримтлагдсан элэгдэл	-517,548,399.11	-305,851,110.48
39217	Ном	55,809,539.11	58,924,143.37
39300	Биет бус хөрөнгө	509,582.98	172,031,166.50
39301	Програм хангамж	3,425,000.00	2,825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,915,417.02	-2,485,833.50
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	171,692,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,170,830,165.16	7,626,616,859.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	53,457,123.00	20,978,333.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	53,457,123.00	20,978,333.00
41300	Өглөг	53,457,123.00	20,978,333.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,329,900.00	0.00
41360	Бусад өглөг	48,127,223.00	20,978,333.00
41361	Байгууллагад төлөх өглөг	48,127,223.00	20,978,333.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,117,373,042.16	7,605,638,526.02
51	Засгийн газрын хувь оролцоо	6,117,373,042.16	7,605,638,526.02
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,472,186,994.87	1,705,625,669.28
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	808,701,165.00
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	0.00	857,710,524.27
51200	Хуримтлагдсан үр дүн	2,811,331,914.30	2,838,964,983.15
51210	Өмнөх үеийн үр дүн	2,625,878,692.06	3,042,110,422.51
51220	Тайлант үеийн үр дүн	185,453,222.24	-203,145,439.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	833,854,132.99	1,394,636,184.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,170,830,165.16	7,626,616,859.02

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,997,720,688.55	3,178,893,957.61
11	ТАТВАРЫН ОРЛОГО	59,083,911.80	59,654,545.35
110	Орлогын албан татвар	36,661,751.80	37,339,325.35
1100	Хувь хүний орлогын албан татвар	36,661,751.80	24,042,123.69
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0	0
110002	Үйл ажиллагааны орлого	22,897,470.00	4,683,697.40
110003	Хөрөнгийн орлого	0	0
110004	Хөрөнгө борлуулсны орлого	0	4,593,720.00
110008	Шууд бус орлого	13,764,281.80	14,764,706.29
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0	13,297,201.66
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	0	13,297,201.66
113	Хөрөнгийн албан татвар	1,930,000.00	2,056,000.00
113002	Бууны албан татвар	1,930,000.00	2,056,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	20,492,160.00	20,259,220.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	20,492,160.00	20,259,220.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,419,160.00	1,650,220.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	450,000.00	1,050,000.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	16,623,000.00	17,559,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	528,478,389.75	654,223,850.26
120	Нийтлэг татварын бус орлого	528,478,389.75	654,223,850.26
120003	Торгуулийн орлого	210,760.00	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	528,267,629.75	654,223,850.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,390,027.00	7,736,360.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,653,606.00	11,068,510.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	515,223,996.75	635,418,980.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,410,158,387.00	2,465,015,562.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,730,514,600.00	1,759,335,214.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	16,000,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,624,920,700.00	1,642,289,600.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	105,593,900.00	101,045,614.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0	0

Айраг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,034,215.00	84,152,197.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,600,000.00	3,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаа гүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,072,000.00	7,520,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгаг дсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,396,580.00	40,777,737.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,965,635.00	32,854,460.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	598,609,572.00	612,537,151.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	323,084,500.00	324,633,500.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	3,661,072.00	19,827,151.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	271,864,000.00	268,076,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0	8,991,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0	8,991,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,712,181,693.42	2,803,630,676.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,712,181,693.42	2,803,630,676.25
